



МОНГОЛ УЛСЫН
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2021 оны 12 сарын 24 өдөр

Дугаар А7307

Улаанбаатар хот

Дөрөвдөгчийн хурдсын шинэ ангилал,
индекс ба гарал үүслийн тэмдэглэгээг батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20.5.14, Ашигт малтмалын тухай хуулийн 10.1.7 дахь заалт, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуралдааны УТХ-09-01 дүгээр зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Дөрөвдөгчийн хурдсын шинэ ангилал, индекс, гарал үүслийн тэмдэглэгээг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2021 оны УТХ-09-01 дүгээр зөвлөмжийн хавсралтад заасны дагуу хүлээн авч баталсугай.

2.Дөрөвдөгчийн хурдсын шинэ ангилал, индекс, гарал үүслийн тэмдэглэгээг олон нийтэд сурталчлан таниулах, хэвлэн нийтлэх, геологичдын хүртээл болгох ажлыг зохион байгуулахыг Үндэсний геологийн албаны дарга О.Чулуун, шаардагдах төсвийг 2022 онд гүйцэтгэх геологийн судалгааны ажлын аргачлал, хяналтын зардлаас санхүүжүүлэхийг Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргалд даалгасугай.

3.Дөрөвдөгчийн хурдсын шинэ ангилал, индекс, гарал үүслийн тэмдэглэгээг бүх төрлийн геологийн судалгаа, хайгуулын ажил гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгжүүдэд 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаанд нь мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үндэсний геологийн албаны дарга О.Чулуун, Ашигт малтмал, газрын тосны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Түвшинжаргал нарт даалгасугай.

4.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Ц.Одхүү)-т үүрэг болгосугай.





УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН
ЗӨВЛӨМЖ

2021 оны 12 сарын 03 өдөр

Дугаар УТХ-09-01

Улаанбаатар хот

“Дөрөвдөгчийн хурдсын шинэ ангилал, индекс ба
гарал үүслийн тэмдэглэгээ” хэлэлцсэн тухай

“Дөрөвдөгчийн хурдсын шинэ ангилал, индекс ба гарал үүслийн тэмдэглэгээ”-г Монголын стратиграфын комиссоос буюу ШУА-ийн Геологийн хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор Ц.Наранцэцэг, ШУТИС-ийн Геологи, гидрогеологийн сургуулийн багш, доктор С.Хишигсүрэн, Монгол Улсын Зөвлөх геологич Ж.Тогтох нар боловсруулж, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд дараах ЗӨВЛӨМЖ-ийг гаргаж байна. Үүнд:

1. Монгол орны хэмжээнд хийгдэж байгаа геологийн судалгаа болон төрөл бүрийн масштабын зураглалын ажлын үр дүнгүүдэд дөрөвдөгчийн хурдсын ангилал, индекс болон тэмдэглэгээний асуудал нь ялгаатай байдлаар хэрэглэгдэж ирсэн, цаашид төрөл бүрийн масштабын геологийн зургуудыг нэгтгэх, харьцуулах ажилд хүндрэл учирч байсан асуудлыг шийдвэрлэх, 2017 онд батлагдсан “Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд 1:50000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг хийх заавар, тавих шаардлага”-ын нэмэлт өөрчлөлт зэрэгт нийцүүлэн “Дөрөвдөгчийн хурдсын шинэ ангилал, индекс ба гарал үүслийн тэмдэглэгээ”-г боловсруулсан байна.

2. Энэхүү ангилал нь 2017 оноос хойш дөрөвдөгчийн хурдсын талаар Олон Улсын ангилалд гарсан өөрчлөлтүүд, тухайлбал плейстоцен ба голоцены дотоод ангилал, хил заагуудыг шинэчилэн тогтоосон өөрчлөлтүүдийг тусгасан байна. Үүнд: Дөрөвдөгчийн систем (галав) дотроо плейстоцен ба голоцен гэсэн 2 сери (галчин)-д ангилагдах ба плейстоцен Гелас (2.58-1.80 сая жил), Калабр (1.80-0.774 сая жил), Чибя (0.774-0.129 сая жил) ба дээд (0.129-0.0117 сая жил) гэсэн 4 стейжид хуваагдаж байна. Харин голоцен нь Гренланд (11.7-8.2 мянган жил), Нортгрип (8.2-4.2 мянган жил) ба Мегал (4.2 мянган жилээс өнөөг хүртэл) хэмээх 3 стейжэд ангилсан байна.

3. Дөрөвдөгчийн хурдсын индекс буюу тэмдэглэгээнд Монгол Улсын 1:200000-ны масштабын номенклатурын хавтгайн “Улсын Геологийн Иж бүрдэл зураг (УГЗ)” зохиох, хэвлэлтэнд бэлтгэх зааварт анх тусгасан тэмдэглэгээний ерөнхий зарчимтай ойролцоо, туслах чанарын тоон символуудыг ашигласан байна. Индексийн тэмдэглэгээнд тухайн зураглалын ажил явагдаж буй бүс нутгийн геологийн тогтоцын онцлогоос шалтгаалсан зарим зохицуулалтыг хийж өгчээ.

4. Дөрөвдөгчийн хурдсын гарал үүслийн тэмдэглэгээг латин нэрний эхний үсгүүдээр тэмдэглэсэн бол вулканоген болон вулкан шавар (грязевые вулканы) хурдсын тэмдэглэгээг хооронд нь ялгах үүднээс “vl” (volcanic) ба “mv” (mud volcano) хэмээн тэмдэглэсэн байна. Жич: Дөрөвдөгчийн гелас ба калабр стейжийг гол төлөв базальтын зузаалгуудын хэмжээнд хэрэглэх боломжтой тул гарал үүслийн тэмдэглэгээнд оруулж өгсөн байна. Харин салхины гаралтай хурдсын латин ба англи нэрний аль ч хувилбар нь аллювийн ба элювийн хурдастай давхцаж байгаа тул “eo” үсгээр тэмдэглэжээ.

Дөрөвдөгчийн хурдсын тэмдэглэгээг хийхдээ хурдсын гарал үүслийн латин нэрний эхний үсгийг жижгээр тэмдэглэн ард нь насыг шинэ индексийн дагуу бичиж өгчээ. Жишээлбэл: алювийн гаралтай дунд плейстоцены Чиба стейжийн хурдсыг “а” гэж тэмдэглэж байхад мөстлөгийн гаралтай дээд плейстоцены хурдсыг “g”, доод плейстоцены Гелас стейжийн вулканоген хурдсыг “v1” гэх зэргээр тэмдэглэсэн байна. Харин нас ба гарал үүсэл нь тодорхойгүй, ангилагдаагүй хурдсанд гарал үүслийн латин нэрний эхний үсгийг аль давамгайлж байгаагаар нь дараалуулан бичиж, насны индексийг эртнийхээс хожуу үеийнх рүү нь мөн дараалуулан дунд нь зураасаар тэмдэглэж бичжээ. Жишээлбэл: делюв-пролювийн гаралтай дунд-дээд плейстоцены хурдсыг “dp”, нуурын гаралтай дунд-дээд голоцены нортгрипп ба мегал стейжийн ангилагдаагүй хурдсыг “l” гэж тус тус тэмдэглэсэн байна.

Монгол Стратиграфын комиссоос боловсруулсан “Дөрөвдөгчийн хурдсын шинэ ангилал, индекс ба гарал үүслийн тэмдэглэгээ”-г Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл хэлэлцээд, гишүүдийн саналыг үндэслэн, тус хуралдаанаас дараах зөвлөмжийг гаргаж Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад уламжлахаар шийдвэрлэв. Үүнд:

1. Дөрөвдөгчийн хурдсын шинэ ангиллыг энэхүү зөвлөмжийн хавсралтын хүснэгт №1, Дөрөвдөгчийн системийн индекс ба стейжүүдийг хүснэгт №2, Дөрөвдөгчийн хурдсын гарал үүслийн төрлүүд ба тэмдэглэгээг хүснэгт №3-ын дагуу хүлээн авах,
2. “Дөрөвдөгчийн хурдсын шинэ ангилал, индекс ба гарал үүслийн тэмдэглэгээ”-г олон нийтэд сурталчилан таниулах, геологичдын хүртээл болгох ажлыг зохион байгуулахыг Монголын стратиграфын комисст даалгах,
3. “Дөрөвдөгчийн хурдсын шинэ ангилал, индекс ба гарал үүслийн тэмдэглэгээ”-г бүх төрлийн геологи, хайгуулын ажил гүйцэтгэж байгаа нийт аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах.

ТАНИЛЦСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МӨРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН ОРЛОГЧ ДАРГА

Б.БАТ

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:

ЭБМЗ-ИЙН САЛБАР
ХУРАЛДААНЫ ДАРГА

А.ДЭЛГЭРСАЙХАН

БОЛОВСРУУЛСАН:

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Ч.БЯМБАЖАВ

Дөрөвдөгчийн хурдсын шинэ ангилал

Хүснэгт №1

МОНГОЛЫН СТРАТИГРАФИЙН КОМИСС									
Монголын дөрөвдөгчийн хурдсын нэгдсэн ангилал, индекс, МСК, 2021									
Эрагем (Эрин)	Систем (Галав)	Сери (Галчин)	Стейж (Зуун)		Нас (с.ж)	Индекс			
КАЙНОЗОЙ	Дөрөвдөгч (Q)	Голоцен (Q ₂)	Дээд/хожуу	Мегал	0.0042	Q ₂ ³	Q ₂	Q	
			Дунд	Нортгтрип	0.0082	Q ₂ ²			
			Доод/түрүү	Гренланд	0.0117	Q ₂ ¹			
		Плейстоцен (Q ₁)	Дээд/хожуу	Дээд/хожуу	0.129	Q ₁ ³	Q ₁		
			Дунд	Чиба	0.774	Q ₁ ²			
			Доод/түрүү	Калабр	1.80	Q ₁ ^{1b}			
				Гелас	2.58	Q ₁ ^{1a}			

Дөрөвдөгчийн системийн индекс ба стейжүүд

Хүснэгт №2

Индекс	Стейж (боломжит хувилбарууд)
Q ₂	Голоцен (Стейжүүд ялгах боломжгүй)
Q ₂ ³	Дээд олоцен (Мегал стейж)
Q ₂ ²⁻³	Дунд-дээд голоцен (Нортгтрип-Мегал стейж)
Q ₂ ²	Дунд голоцен (Нортгтрип стейж)
Q ₂ ¹⁻²	Доод-дунд голоцен (Гренланд-Нортгтрип стейж)
Q ₂ ¹⁻²	Дээд плейстоцен-голоцен (Голоцены стейж ялгах боломжгүй)
Q ₁ ³ -Q ₂ ¹	Дээд плейстоцен-доод голоцен (Гренланд стейж)
Q ₁ ³	Дээд плейстоцен
Q ₁ ²⁻³	Дунд-дээд плейстоцен
Q ₁ ²	Дунд плейстоцен (Чиба стейж)
Q ₁ ^{1b-2}	Доод-дунд плейстоцен (Калабр-Чиба стейж)
Q ₁ ¹⁻²	Доод-дунд плейстоцен (Гелас, калабр стейж ялгах боломжгүй)
Q ₁ ¹	Доод плейстоцен (Гелас, калабр стейж ялгах боломжгүй)
Q ₁ ^{1b}	Доод плейстоцен (Калабр стейж)
Q ₁ ^{1a}	Доод плейстоцен (Гелас стейж)

Тэмдэг- лэгээ	Дөрөвдөгчийн хурдсын гарал үүслийн төрлүүд			
	Монгол	Латин	Англи	Орос
e	Элюви	eluo	eluvium	Элювиальные
d	Делюви	deluo	diluvium	Делювиальные
a	Аллюви	alluvius	alluvium	Аллювиальные
p	Пролюви	proluvium	proluvium	Пролювиальные
c	Коллюви	colluvio	Colluvium	Коллювиальные
s	Солифлюкци	Solum - fluctio	solifluction	Солифлюкционные
l	Нуур	lacus	Lacustrine	Озерные
g	Мөстлөг	glacies	Glacial	Ледниковые
v	Салхины гаралтай	Aeolus	Aeolian (eolian)	Эоловые
ed	Элюви-делюви	x	x	Элювиальные и делювиальные
dc	Делюви-коллюви	x	x	Делювиальные и коллювиальные
cs	Коллюви- солифлюкци	x	x	Коллювиальные и солифлюкционные
ds	Делюви-солифлюкци	x	x	Делювиальные и солифлюкционные
ad	Аллюви-делюви	x	x	Аллювиальные и делювиальные
ap	Аллюви-пролюви	x	x	Аллювиальные и пролювиальные
pd	Пролюви-делюви	x	x	Пролювиальные и делювиальные
la	Нуур-аллюви	x	x	Озерно- аллювиальные
lp	Нуур-пролюви	x	x	Озерные и пролювиальные
lg	Нуур-мөстлөг	x	x	Озёрно-ледниковые
gl	Мөстлөг-нуур	x	Glacialacustrine	Ледниковоозерные (Гляциолимнические)
fg	Ус-мөстлөг (Флювиогляци)	x	Fluvioglacial	Водно-ледниковые (флювиогляциальные)
gf	Мөстлөг-ус (Гляциофлюви)	x	Glaciofluvial	Водно-ледниковые (гляциофлювиальные)
vl	Вулканоген	volcanus	volcanic	Вулканогенные
mv	Шавар вулкан	lutus volcanus	Mud volcanoes	Грязевулканические
bg	Биоген гаралтай	biogen	Biogenic	Биогенные
ch	Химийн гаралтай	Chimia, alchimia	Chemical	Химические (хемогенные)
tg	Техноген	Techno genic	Technogenic	Техногенные